

## “Эрдэнэс сольюшинс” ХК

/хуучнаар Хар хорум пропертийс ХК/

### **КОМПАНИЙН 2020 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН**

**1. АГУУЛГА**

1. АГУУЛГА .....	2
2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР .....	3
3. КОМПАНИЙН ТУХАЙ .....	4
1. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас .....	4
2. Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, регистрийн дугаар, бүртгэсэн огноо, сар, өдөр .....	4
3. Компанийн санхүүгийн бус мэдээлэл:.....	4
5. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтаны цалин урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл.....	12
КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ .....	13
6. Авлага, өр төлбөрийн задаргаа .....	17
7. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компанийн талаарх мэдээлэл, хяналтын багц, ҮЦЗЗТХ-ийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээдүүдийнх нь тухай мэдээлэл.....	18
8. Компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд бусадтай байгуулсан гэрээ хэлцэл, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн талаар .....	19
9. Компанийн ноогдол ашгийн талаар.....	21
10. Охин компаниудын тухай .....	21
11. Худалдан авч буй охин компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан .....	24

## 2. ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

---

ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
ББӨ	Борлуулсан бүтээгдэхүүний өртөг
ЗГ	Засгийн газар
КТХ	Компанийн тухай хууль
МУ	Монгол Улс
МХБ	Монголын Хөрөнгийн Бирж
НА	Ногдол ашиг
НББ	Нягтлан бодох бүртгэл
НББОУС	Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
СЗХ	Санхүүгийн Зохицуулах Хороо
СТОУС	Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт
ТУЗ	Төлөөлөн Удирдах Зөвлөл
УИХ	Улсын Их Хурал
ҮЦТХТ	Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК
ҮЦБЖ	Үнэт цаасны бүртгэлийн журам
ҮЦЗЗТХ	Үнэт цаасны зах зээлийн тухай хууль
ХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХК	Хувьцаат компани
ХХН	Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл
ХЭХ	Хувьцаа эзэмшигчдийн хурал
ХЭЭБХ	Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурал
ШУТИС	Шинжлэх Ухаан Технологийн их сургууль
ШШГГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар
СЭЗДС	Санхүү эдийн засгийн дээд сургууль

---

### 3. КОМПАНИЙН ТУХАЙ

#### 1. Компанийн оноосон нэр, оршин байгаа хаяг, холбоо барих утас

**Компанийн нэр:** “Эрдэнэс сольюшинс” Хувьцаат Компани

**Компанийн хаяг:** Монгол улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, дүгээр хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффисын 401

#### 2. Компанийн хуулийн этгээдийн улсын бүртгэл, регистрийн дугаар, бүртгэсэн огноо, сар, өдөр

Компанийн нэр:	“Эрдэнэс сольюшинс” ХК
Үүсгэн байгуулагдсан огноо:	1996.04.20
Улсын бүртгэлийн дугаар:	9010001131
Регистрийн дугаар:	2015358
Үйл ажиллагааны чиглэл:	<ul style="list-style-type: none"><li>- Програм хангамжийн үйл ажиллагаан /код-62010/</li><li>- Програм хангамж, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа /код-47410/</li><li>- Вэб сайт хийх /код-63120/</li><li>- Мэдээлэлийн технологийн үйл ажиллагаа /код-63990/</li><li>- Худалдааны зуучлал /код- 46100/</li></ul>
Хувьцаа эзэмшигчдийн тоо:	191 хувьцаа эзэмшигчидтэй. /2021 оны 03-р сарын 31-ний өдрийн эцсийн байдлаар тархалтын судалгаа/
Монголын хөрөнгийн биржийн хувьцааны арилжааны ангилал:	Үнэт цаасны бүртгэлийн III-р ангилал

#### 3. Компанийн санхүүгийн бус мэдээлэл:

Компанийн үйл ажиллагаа 2020 оны 01-р сарын 01-ний байдлаар дараах байдалтай байсан:

Компани 2002 оны оос хойш идэвхтэй үйл ажиллагаа явуулаагүй бөгөөд төлбөрийн чадваргүйн улмаас Монголын хөрөнгийн биржийн жил тутмын бүртгэлийн хураамжийн өр 2020 оны 01–р сарын 01-ний өдрийн байдлаар 6’397’912 төгрөгт хүрч Монголын хөрөнгийн бирж хуримтлагдсан бүртгэлийн хураамжийг төлүүлэхээр Чингэлтэй дүүргийн шүүхэд өгсөн байсан. Үүнд:

Монголын хөрөнгийн биржид 2002 – 2007 он- 240,000 төгрөг, 2008 - 2011 он- 57,912 төгрөг, 2012-2014 он – 3,600,000 төгрөг, 2015-2018 он- 2,000,000 төгрөг, 2019 он-500,000 төгрөг, Нийт

6,397,912 төгрөг, “Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв”-д хувьцаагаа хадгалуулсаны үйлчилгээний хуримтлагдсан төлбөр өрийн хуримтлагдсан хэмжээ 2012 он- 60,000 төгрөг, 2013 он - 60,000 төгрөг, 2014 он- 60,000 төгрөг, 2015 он- 60,000 төгрөг, 2016 он- 60,000 төгрөг, 2017 он- 100,000 төгрөг, 2018 он- 100,000 төгрөг, 2019 он- 100,000 төгрөг, Нийт 600,000 төгрөг тус тус байсан.

Тус компанийн өөрийн хөрөнгө 2020 оны 01-р сарын 01-ний байдлаар хасах 10'759'585.40 төгрөгт хүрч, өр нь 10'804'885.40 төгрөгт тус тус хүрсэн байсан нь Компанийн тухай хуулийн 61.1.3-т заасан компанийн алдагдал тухайн тайлант үеийн эцэст өөрийн хөрөнгийн 30 хувиас хэтэрсэн, 61.1.4-т заасан компанийн өр нь хоёр жил дараалан өөрийн хөрөнгөнөөс илүү болж, хасах утгатай болсон тохиолдолд хуулийн 61 дүгээр зүйлийн дагуу Хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах нөхцөл үүсгээд байсан.

Компани нь нэг бүрийн 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт 36'195 ширхэг гаргасан энгийн хувьцаатай байх бөгөөд Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу компани нь нийт 3'619'500 төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй хамгийн сүүлд 2013 оны 06-р сарын 07 өдөр 1 ширхэг хувьцаа 78 төгрөгөөр нэрлэсэн үнээсээ доогуур арилжигдаж, өнөөдрийн байдлаар ердөө зах зээлийн үнэлгээ 2,823,210 төгрөгийн үнэлгээтэй компани болсон байсан бөгөөд 2020 оны 01-р сарын 01-ний өдрийг хүртэл нэг ч хувьцааны арилжаа хийгдээгүй, идэвхгүй байсан.

Компанийн оноосон нэрийг сольж сүүлийн 5 жилийн турш өөрчлөлт хийж, үйл ажиллагаагаа идэвхжүүлэх гэж оролдсон боловч Монгол улсын эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн хүндрэл, хөрөнгө оруулагчдын сонирхол байхгүй зэргээс болж компани ямар нэгэн үйл ажиллагаа явуулж чадсангүй. Түүнчлэн Гүйцэтгэх захирал Д. Энхбаатар нь энэ хугацаанд одоо болтол олдохгүй байгаа бөгөөд ямар нэгэн байдлаар холбогдож чадаагүй байсан.

Компанид СЗХ-ны 2016 оны 01-р сарын 27-ны өдрийн 9/249 албан тоот бичгээр ирүүлсэн “Хууль журмын хэрэгжилтийг хангаж ажиллах талаар зөвлөгөө хүргүүлэх тухай”, 2017 оны 01-р сарын 20-ны өдрийн 9/210 тоот “Даалгавар өгөх тухай” албан бичгээр ирүүлсэн бичгүүдэд компанийг удаа дараа Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль баримтлан ажиллах, компанийн үнэлгээ хийлгэх тухай шаардлагуудыг удаа дараа ирүүлсэн байсан бөгөөд компанийн цаашдын үйл ажиллагаа ийм хэвээр үргэлжилбэл санхүүгийн байдал эрс муудаж, төлбөрийн чадваргүй болж Шүүхийн шийдвэрээр үйл ажиллагаагаа бүрмөсөн зогсоож, дампуурах эрсдэлтэй болсон байна гэж үзэж байна. Ийм тохиолдолд компанийн хувьцаа эзэмшигч 130 гаруй иргэн, хуулийн этгээд бүрэн хохирох эрсдэлтэй байсан.

Компанийн хувьцаа эзэмшигчдээс компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлыг 2020 оны 01-р сарын 24-ний өдөр хуралдуулан ХЭХ-аас “Хар хорум пропертийс” ХК болон “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон санхүүгийн тайлан, хөрөнгийн үнэлгээний тайланд үндэслэн “Хар хорум пропертийс” ХК-ийн нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1 ширхэг энгийн хувьцаанд “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийн нэг бүр нь 1 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 100 ширхэг энгийн хувьцаатай хувь тэнцүүлэн хөрвүүлж нэгтгэх замаар өөрчлөн байгуулах шийдвэр гарсаны дагуу СЗХ-ны 2020 оны 02-р сарын 28-ны өдрийн 80 тоот тогтоолоор компанид “Эрдэнэс сольюшинс ХХК”-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулсан.

Нэгтгэлийн дагуу компанийн зарласан энгийн хувьцаанаас хаалттай хүрээнд 1 ширхэг нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'751'262 ширхэг энгийн хувьцааг хаалттай хүрээнд эргэлтэд нэмж

гарган нийт нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 15'787'457 ширхэг энгийн хувьцаатай болсон.

Улсын бүртгэлийн ерөнхий газрын Хуулийн этгээдийн бүртгэлийн газар 2020 оны 06-р сарын 28-ний өдөр нэгтгэлийг бүртгэсэн.

ХЭ 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн хуралдаанаар “Хар хорум пропертийс” ХК-ийн оноосон нэрийг “Эрдэнэс сольюшинс” ХК болгохоор шийдвэрлэсэнийг СЗХ-ны даргын 2020 оны 08-р сарын 14-ны өдрийн 272 тоот тушаалаар зөвшөөрч компанийн оноосон нэрийг өөрчилсөн.

ХЭ 2020 оны 01-р сарын 24-ний өдрийн хуралдаанаас Төлөөлөн удирдах зөвлөлийг 3 жилийн хугацаатайгаар шинээр Ердийн гишүүнээр: Ц.Хүдэрмөнх, Т.Золбоо, Б.Батхүү, Ц.Хишигбаатар, Э.Цэндсүрэн, Г.Азжая, Хараат бус гишүүнээр: Б.Энхзориг, С.Энхжаргал, П.Нарантунгалаг нарыг сонгосон.

ХЭ 2020 оны 04-р сарын 29-ний өдрийн хуралдаанаас компанийн 15,787,457 ширхэг энгийн хувьцааг 10 хувааж 157,874,570 ширхэг болгохоор шийдвэрлэсэнийг СЗХ-ны 2021 оны 01-р сарын 13-ны өдрийн 01 тоот тогтоолоор зөвшөөрсөн.

#### **4. Компанийн бизнесийн үйл ажиллагааны талаарх мэдээлэл**

Компани 2020 онд “Эрдэнэс сольюшинс” ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулж технологийн чиглэлд үйл ажиллагаа эрхлэх болсоноор дараах бүтээгдэхүүнийг хөгжүүлж, үйл ажиллагаагаа дараах компанийн хувьцааг худалдан авч өргөжүүлсэн болно.

Компанийн ТУЗ-ын 2021 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор компани СЗХ-ны гадаад валютын арилжааны тусгай зөвшөөрөл бүхий “Эйс ассошиэйтс ББСБ”-ын 85%-ийг худалдан авах, СЗХ-ны үнэт металлын арилжааны “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн 90%-ийг худалдан авахаар шийдвэрлэсэн.

Үүнээс “Эйс ассошиэйтс” ББСБ-ын 85%-ийг 2021 оны 01-р сард сард худалдан авч, худалдан авахыг зөвшөөрсөн СЗХ-ны зөвшөөрөл гарсан. Энэ ББСБ-ын хувь нийлүүлсэн хөрөнгийг 2021 онд нэмэгдүүлэн зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг авах болно. Гар утас ашиглан онлайн зээл олгох үйл ажиллагааг 2021 оны 3-р улиралд эхлүүлнэ.

Компани гадаад валютын арилжааны зах зээлийг хөгжүүлэх зорилгоор 2019 онд “Эрдэнэс капитал маркетс” ХХК үүсгэн байгуулсан. Компанийн програм хангамж, системийг хөгжүүлж байна. Компанийн програм хангамж, системийг хөгжүүлж байна.


Компанийн ТУЗ-ын 2021 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор хаа, аялал жуулчлалын үйл ажиллагаа эрхлэх зорилгоор “Эрдэнэс агро энд ресортс” ХХК-ийг үүсгэн байгуулж, үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг СЗХ-оос 2020 оны 05-р сарын 20-ны өдөр ТЗ601/54 тоот зөвшөөрлийг авсан. Үйл ажиллагаанд хөдөө аж ахуйн технологийн шийдэлийг нэвтрүүлж 2021 оны 4-р улиралд үйл ажиллагааг эхлүүлнэ.

“Хар хорум пропертийс” ХК нь үл хөдлөх хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд ТУЗ-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗТ 06/2020 тоот тогтоолоор “Эрдэнэс рийс эстэйт” ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагааг тусгаарласан. СЗХ-ны 2020 оны тоот ТЗ 601/54 тогтоолоор үл хөдлөх хөрөнгийн зуучлалын тусгай зөвшөөрөл авсан.


Үл хөдлөх хөрөнгө бүртгэлийн програм хангамж, платформыг хөгжүүлж байгаа бөгөөд 2022 оны 1-р улиралд ажилуулахаар төлөвлөж байна.

**Эрдэнэ сольюшинс ХК-ний бүтэц зохион байгуулалт**

Компани нь 2020 оны 12-р сарын 31-ний байдлаар дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:



Компани нь 2021 оны 03-р сарын 31-ний байдлаар дараах бүтэцтэйгээр үйл ажиллагаа явуулж байна. Үүнд:



**Компанийн хөгжүүлсэн програм хангамж**

№	ПРОГРАМХАНГАМЖИЙН НЭЭР	АЖЛЫН ЯВЦ	ДУУСЛАСАН ХУГАЦАА	ХЭНД
1	Үнэт цаасны арилжааны төлбөр тооцооны систем	██████████	2019 оны 2-р ул.	Ариг банк
2	Сууц өмчлөгчдийн холбооны мобайл апп	██████████	2020 оны 1-р ул.	Хангал систем ХХК
3	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газрын вэб	██████████	2020 оны 3-р ул.	Нийслэлийн шинжлэх ухаан, үйлдвэрлэл, инновацын газар
4	Дотоод бүртгэлийн систем	██████████	2021 оны 2-р ул.	Үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо

### Компанийн хөгжүүлж буй төсөл болон програм хангамжууд

Банк бус санхүүгийн байгууллагын бүртгэлийн болон онлайн зээлийн систем програм хангамж;

Брокерийн компанийн арилжааны платформ бүхий БрокерсMN систем;

№	ПРОГРАМХАНГАМЖИЙН НЭР	АЖЛЫН ЯВИ	ДЭУСАХ ХУГАЦАА	ХЭНД
1	БрокерсMN арилжааны платформ		2021 оны 3-р ул.	Үнэт цаасны брокерийн компаниуд
2	ББСБ-ын үндсэн програм хангамж		2021 оны 3-р ул.	Эйс ассошиэйтс ББСБ
3	Зээлжүүлэх зэрэглэл тогтоох, зээл олгох модуль		2021 оны 3-р ул.	Эйс ассошиэйтс ББСБ
4	Валют арилжааны платформ		2021 оны 4-р ул.	Эрдэнэс капитал маркетс ХХК
5	Үнэт металл арилжааны платформ		2021 оны 4-р ул.	Эрдэнэс коммодитийс трейдинг ХХК
6	Үл хөдлөх хөрөнгө зуучлалын модуль		2022 оны 1-р ул.	Эрдэнэс рийл эстэйт ХХК

### Компанийн удирдлагын мэдээлэл

Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь ээлжит болон ээлжит бус байна. Компанийн бүтэц зохион байгуулалтын хувьд дараах схемийн дагуу үйл ажиллагаагаа явуулж байна.

Компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт компанийн эрх барих дээд байгууллага нь төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) байна. ТУЗ нь компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийг тогтоох, гүйцэтгэх удирдлагыг сонгох, ажилд нь хяналт тавих зэрэг үйл ажиллагааг авч хэрэгжүүлэхээс гадна Компанийн тухай хууль болон компанийн дүрэмд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах зээг ажлуудыг зохион байгуулдаг. Компанийн ТУЗ нь 9 гишүүнтэй ба ТУЗ-ийн гишүүдийг 3 жилийн хугацаатай сонгодог байна.

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас дараах гишүүд ТУЗ-ийн гишүүдээр сонгогдсон байна.

Хүснэгт 1. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ-ийн гишүүд

Овог, нэр	Албан тушаал
1 Ц.Хүдэрмөнх	ТУЗ-ийн ердийн гишүүн
2 Т.Золбоо	ТУЗ-ийн ердийн гишүүн
3 Ц.Хишигбаатар	ТУЗ-ийн ердийн гишүүн
4 Г.Аззаяа	ТУЗ-ийн ердийн гишүүн
5 Э.Цэндсүрэн	ТУЗ-ийн ердийн гишүүн
6 Б.Батхүү	ТУЗ-ийн ердийн гишүүн
7 Б.Энхзориг	ТУЗ-ийн хараат бус гишүүн



8	С.Энхжаргал	ТУЗ-ийн хараат бус гишүүн
9	П.Нарантунгалаг	ТУЗ-ийн хараат бус гишүүн

## Хүснэгт 2. ТУЗ-ийн гишүүдийн боловсрол, ажлын туршлага

Нэр	Боловсрол	Ажлын туршлага
<b>Ердийн гишүүд:</b>		
<b>Ц.Хүдэрмөнх</b>	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр төгссөн.	Хас банкинд систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээчээр 2009-2016 онд, Бодь даатгал ХХК-д системийн шинжээч, цахим банкны хэлтэсийн захиралаар 2016-2018 онд, ISOL ХХК-д мэдээлэлийн технологийн хэлтсийн захиралаар ажиллаж байсан. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна.
<b>Т.Золбоо</b>	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр, 2012 онд магистр зэрэгтэйгээр тус тус төгссөн.	Каракас зураг ХХК-д програмистаар 2006-2007, МИАТ ХК-д програмистаар 2007-2009, Алтан тариа ХК-д системийн шинжээчээр 2009-2010 онуудад ажиллаж байсан. ШУТИС-Мэдээлэл холбооны технологийн сургуульд 2010 оноос хойш өнөөдрийг хүртэл багшаар ажиллаж байна. Япон улсад болсон олон улсын Прокон програм хангамжийн тэмцээний 2005 оны түрүү байрын, Програмчлалын дэлхийн аваргын АСМ2005 тэмцээний 2005 оны тусгай байрын шагналтай.
<b>Ц.Хишигбаатар</b>	Ховд аймгийн 10-н жилийг 1989 онд бүрэн дунд боловсрол төгссөн.	Хувиараа ажиллаж байна.
<b>Г.Аззаяа</b>	Нийслэлийн Оюуны ундраа цогцолбор сургуулийг 1998 онд	Союз номин ХХК-д 2006 оноос хойш харуулын захирлаар ажиллаж байна.

	бүрэн бус дунд боловсрол төгссөн.	
<b>Э.Цэндсүрэн</b>	Япон улсын Шинсү Их Сургуулийг 2009 онд барилга, дэд бүтцийн инженерийн бакалаврын зэрэгтэйгээр төгссөн.	Говь ХК-д үйлдвэр хариуцсан ахлах менежерээр 2009-2011, Бридж групп-д Технологийн инженерээр 2011-2011, Таван богд трейд ХХК-д брэнд менежер, төслийн менежерээр 2011-2015, Монос Улаанбаатар ХХК-д 2015-2017 онуудад төслийн менежерээр ажиллаж байсан. Шинэ Монгол Коосэн технологийн коллеж-д 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
<b>Б.Батхүү</b>	Санхүү эдийн засгийн дээд сургуулийг банк санхүүгийн бакалавр зэрэгтэйгээр 1997 онд төгссөн.	ХХБ-д эдийн засагч, ахлах эдийн засагч, Үйл ажиллагаа харуцсан захирал 1996-2004, УБХБ-д Хөрөнгө зохицуулатын газрын захирал, Дэд захирал, Гүйцэтгэх захирал 2004-2007, Капитрон банкинд Гүйцэтгэх захирлын зөвлөх, ҮАБЗАА-нд банк санхүү хариуцсан референт 2009-2011 онуудад ажиллаж байсан. Экспонэйшнл фонд менежмент ҮЦК ХХК-д 2011 оноос хойш өнөөдрийг хүртэл Гүйцэтгэх захиралаар ажиллаж байна.
<b>ТУЗ-ийн хараат бус гишүүд:</b>		
<b>П.Нарантунгалаг</b>	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр, ШУТИС-КТМС-ийг 2013 онд магистраар тус тус төгссөн.	Интерактив ХХК-д програмист мэргэжлээр 2007-2012 онд ажиллаж байсан. Хас банкинд 2012 оноос хойш өнөөдрийг хүртэл систем аналитаар ажиллаж байна.
<b>Б.Энхзориг</b>	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр, Хүмүүнлэгийн ухааны их сургуулийг 2013 онд англи хэлний орчуулагч мэргэжлээр бакалаврын зэрэгтэйгээр, СЭЗДС-ийг 2016 онд Бизнесийн удирдлагын магистраар тус тус төгссөн.	Хасабэ интернэйшнл ХХК-д захиргааны ажилтан 2006-2007 онд, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яаманд НҮБ-ын хөгжлийн хөтөлбөрийн төслийн нарийн бичгийн даргаар 2008-2011 онд, Швейцарын хөгжлийн агентлаг/Монголын хөгжил судлал төвд төслийн менежерээр 2011-2014 онуудад ажиллаж байсан.

		СЭЗДС-д 2014 оноос хойш өнөөдрийг хүртэл сургалтын менежер багшаар ажиллаж байна.
<b>С.Энхжаргал</b>	УБИС-ийг 2002 онд дүрслэх урлаг дизайны бакалавр зэрэгтэйгээр төгссөн.	Говь ХК-д дизайнераар 2003, Эдмон ХХК-д дизайнераар 2004, Мон хорус интернэйшнл ХХК-д 2008-2019 гэрээт дизайнераар ажиллаж байсан. Авто ойл ХХК-д гэрээт дизайнераар 2019 оноос хойш өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

### ТУЗ-ийн дэргэдэх хороод:

2011 оноос хэрэгжиж эхэлсэн “Компанийн тухай хууль”-ийн шинэчилсэн найруулгаар хувьцаат компанийн хувьд ТУЗ-ийн дэргэд тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороодыг байгуулахаар заасан. Компанийн 2020 оны 01 дүгээр сарын 24-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас сонгогдсон ТУЗ-ийн бүрэлдэхүүн нь ТУЗ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 28-ны өдрийн №ТУЗТ 02/2020 тогтоолоор ТУЗ-ийн дэргэдэх аудитын, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүдийг шинэчлэн томилсон байна.

ТУЗ-ийн дэргэдэх хороод нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

Хүснэгт 3. ТУЗ-ийн дэргэдэх хороодын бүрэлдэхүүн

<b>Цалин, урамшууллын хороо</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Т.Золбоо- /Хорооны дарга/</li> <li>2. С.Энхжаргал</li> <li>3. Б.Энхзориг</li> </ol>
<b>Аудитын хороо</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. П.Нарантунгалаг- /Хорооны дарга/</li> <li>2. С.Энхжаргал</li> <li>3. Э.Цэндсүрэн</li> </ol>
<b>Нэр дэвшүүлэх хороо</b>	<ol style="list-style-type: none"> <li>1. Б.Энхзориг- /Хорооны дарга/</li> <li>2. Ц.Хүдэрмөнх</li> <li>3. П.Нарантунгалаг</li> </ol>

### Гүйцэтгэх захирал:

Хүснэгт 4. Гүйцэтгэх захирал, алба хариуцсан захирлуудын боловсрол, ажлын туршлага


Нэр	Боловсрол	Ажлын туршлага
<b>Ц.Хүдэрмөнх</b> Гүйцэтгэх захирал	ШУТИС-КТМС-ийг 2007 онд програм хангамжийн бакалавр зэрэгтэйгээр төгссөн.	Хас банкинд систем хөгжүүлэгч, систем дизайнер, системийн шинжээч, системийн ахлах шинжээчээр, төслийн удирдагч, бизнесийн ахлах шинжээчээр 2009-2016 онд, Бодь даатгал ХХК-д

системийн шинжээч, цахим банкны хэлтэсийн захиралаар 2016-2018 онд, ISOL ХХК-д мэдээлэлийн технологийн хэлтсийн захиралаар ажиллаж байсан. Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар 2019 оноос, 2020 оноос хойш Эрдэнэс сольюшинс ХХК-ийн Гүйцэтгэх захиралаар өнөөдрийг хүртэл ажиллаж байна.

**5. Компанийн ТУЗ, Гүйцэтгэх удирдлага болон бусад эрх бүхий албан тушаалтаны цалин урамшууллын хэмжээ, тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны талаарх мэдээлэл**

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 1 бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 ширхэг бөгөөд 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэх өдрийн байдлаар нийт 150 гаруй хувьцаа эзэмшигчтэй байна.

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн ТУЗ-ын дарга Т. Золбоо, Гүйцэтгэх захирал Ц. Хүдэрмөнх нарын нийт гаргасан энгийн хувьцааны эзэмшлийн талаарх мэдээлэл:



Компанийн Гүйцэтгэх захирал Ц. Хүдэрмөнх нь “Эрдэнэс сольюшинс” ХХК ажиллаж байхдаа сарын 3.5 сая төгрөгийн цалин авч байсан бөгөөд компанийг нэгтгэсэний дараа энэ цалингийн хэмжээг хэвээр үргэлжлүүлсэн. Компанийн ТУЗ-ын 2020 оны 03-р сарын 06-ны өдрийн ТУЗТ 03/2020 тоот тогтоолоор Ц. Хүдэрмөнхийг компанийн Гүйцэтгэх захирлаар томилсон бөгөөд, ТУЗ-ын 2020 оны 07-р сарын 07-ны өдрийн ТУЗТ 09/2020 тоот тогтоолоор дээр дурьдсан цалинг баталгаажуулсан тогтоол гаргасан.

Компанийн бусад ТУЗ-ын гишүүд болон эрх бүхий албан тушаалтанууд одоогоор ямар нэгэн цалин, урамшуулал аваагүй болно.

### КОМПАНИЙН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЛААРХ МЭДЭЭЛЭЛ

2020 оны санхүүгийн тайланд аудит хийсэн “Пи Кэй Эф Монголиа” ХХК нь “Бидний дүгнэлтээр, компанийн тусдаа санхүүгийн тайлан нь 2020 оны 12 дугаар сарын 31-ны өдрөөрх санхүүгийн байдал, тухайн өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг зүйлсийн хувьд Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлсэн байна” гэсэн дүгнэлтийг гаргасан байна.

### Санхүүгийн Байдлын Тайлан

Хүснэгт 5. “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн сүүлийн 3 жилийн санхүүгийн байдлын тайлан зэрэгцүүлсэн дүнгээр (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019	2020
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө			17,066,189.35
Дансны авлага			
Бараа материал			24,660,000.00
Урьдчилж төлсөн зардал/тооцоо			33,575,000.00
<b>Эргэлтийн хөрөнгийн дүн</b>			<b>75,301,189.35</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Үндсэн хөрөнгө	45,300.00	45,300.00	
Биет бус хөрөнгө	45,300.00	45,300.00	1,528,455,912.09
Урт хугацаат хөрөнгө оруулалт			20,060,000.00
<b>Эргэлтийн бус хөрөнгийн дүн</b>			<b>1,548,515,912.09</b>
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>45,300.00</b>	<b>45,300.00</b>	<b>1,623,817,101.44</b>
<b>Өр төлбөр эздийн өмч</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Дансны өглөг	7,704,885.40	10,804,885.40	30,032,388.20
Цалингын өглөг			21,959,750.00
Татвар, НДШ-ийн өр			6,413,241.81
Бусад богино хугацаат өр төлбөр			148,427,000.00
<b>Богино хугацаат өр төлбөрийн нийт дүн</b>	<b>7,704,885.40</b>	<b>10,804,885.40</b>	<b>206,832,380.01</b>
<b>Урт хугацаат өр төлбөрийн дүн</b>			
<b>Өр төлбөрийн нийт дүн</b>	<b>7,704,885.40</b>	<b>10,804,885.40</b>	<b>206,832,380.01</b>
<b>Эздийн өмч</b>			
Өмч :			
- Төрийн	0.00	0.00	0.00
- Хувийн	0.00	0.00	0.00
- Хувьцаат	3,619,500.00	3,619,500.00	1,578,745,700.00
Хуримтлагдсан ашиг	(11,279,085.40)	(14,379,085.40)	(161,760,978.57)

Эздийн өмчийн дүн	<b>(7,659,585.40)</b>	<b>(10,759,585.40)</b>	<b>(1,416,984,721.43)</b>
Өр төлбөр ба эздийн өмчийн дүн	<b>45,300.00</b>	<b>45,300.00</b>	<b>1,623,817,101.44</b>

### Орлогын Дэлгэрэнгүй Тайлан

Хүснэгт 6. “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн сүүлийн 3 жилийн орлогын тайлан зэрэгцүүлсэн дүнгээр (төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019	2020
Борлуулалтын орлого (цэвэр)	0.00	0.00	19,160,000.00
Борлуулалтын өртөг	0.00	0.00	0.00
Нийт ашиг (алдагдал)	0.00	0.00	19,160,000.00
Бусад орлого			2,102,623.71
Ерөнхий ба удирдлагын зардал	0.00	3,100,000.00	168,644,516.88
Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	0.00	(3,100,000.00)	(147,381,893.17)
Орлогын татварын зардал	0.00	0.00	0.00
Татварын дараахь ашиг (алдагдал)	0.00	(3,100,000.00)	(147,381,893.17)
Зогсоосон үйл ажиллагааны татварын дараахь ашиг (алдагдал)			
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	0.00	(3,100,000.00)	(147,381,893.17)
Бусад дэлгэрэнгүй орлого	0.00	0.00	0.00
Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү		0.00	0.00
Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		0.00	0.00
Бусад олз (гарз)		0.00	0.00
Орлогын нийт дүн	0.00	(3,100,000.00)	(147,381,893.17)

### Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)

--	--	--	--

### Мөнгөн Гүйлгээний Тайлан

Хүснэгт 7. “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн сүүлийн 3 жилийн мөнгөн гүйлгээний тайлан(төгрөгөөр)

ҮЗҮҮЛЭЛТ	2018	2019	2020
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00	<b>19,160,000.00</b>
Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого			19,160,000.00
Бусад мөнгөн орлого			
Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00	<b>121,431,450.96</b>
Ажиллагсдад төлсөн			21,234,690.00
Бараа материал худалдан авахад төлсөн			43,162,000.00
Ашиглалтын зардалд төлсөн			27,243,700.00
Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн			27,763,772.06
Татварын байгууллагад төлсөн			2,027,288.90
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	0.00	0.00	<b>(102,271,450.96)</b>
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00	2,623.71

Хүлээн авсан хүүний орлого			2,623.71
Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00	<b>20,128,000.00</b>
Биет бус хөрөнгө олж, эзэмшихэд төлсөн			88,000.00
Хөрөнгө оруулалт олж, эзэмшихэд төлсөн			20,040,000.00
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(20,125,376.29)</b>
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	0.00	0.00	<b>139,463,046.60</b>
Зээл авсан, өрийн үнэт цаас гаргасанаас хүлээн авсан			139,463,046.60
Мөнгөн зарлагын дүн (-)	0.00	0.00	<b>30.00</b>
Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн			30.00
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>139,463,016.60</b>
<b>Бүх цэвэр мөнгөн гүйлгээ</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>17,066,189.35</b>
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00	0.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00	17,066,189.35

## Өмчийн өөрчлөлтийн тайлан

2020 оны 12-р дугаар сарын 31-ний өдөр

Хүснэгт 8. “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн 2020 оны жилийн өмчийн өөрчлөлтийн тайлан

ҮЗҮҮЛЭЛТ	Өмч	Халаасны хувьцаа	Нэмж төлөгдсөн капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг	Нийт дүн
2018/12/31 –ний үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(11,279,085.40)	(7,659,585.40)
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3,619,500.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(11,279,085.40)</b>	<b>(7,659,585.40)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						(3,100,000.00)	(3,100,000.00)
Бусад дэлгэрэнгүй орлого							0.00
Өмчид гарсан өөрчлөлт							0.00
Зарласан ногдол ашиг							0.00
Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн							0.00
2019/12/31 –ний үлдэгдэл	3,619,500.00	0.00	0.00	0.00	0.00	(14,379,085.40)	(10,759,585.40)
НББүртгэлийн бодлогын өөрчлөлтийн нөлөө, алдааны залруулга							0.00
<b>Залруулсан үлдэгдэл</b>	<b>3,619,500.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(14,379,085.40)</b>	<b>(10,759,585.40)</b>
Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)						(147,381,893.17)	(147,381,893.17)
Бусад дэлгэрэнгүй орлого							0.00
Өмчид гарсан өөрчлөлт	1,575,126,200.00						1,575,126,200.00
Зарласан ногдол ашиг							0.00
<b>2020/12/31 –ний үлдэгдэл</b>	<b>1,578,745,700.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>	<b>(161,760,978.57)</b>	<b>1,416,984,721.43</b>

“Эрдэнэ сольюшинс” ХК-ийн аудитын тайлангийн дэлгэрэнгүйг үнэт цаасны танилцуулгын хавсралтаас үзнэ үү.



## 6. Авлага, өр төлбөрийн задаргаа

### Авлагын задаргаа

12 дугаар сарын 31-ний өдрөөрх дансны болон бусад авлагын дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

Хүснэгт 9. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2020 оны жилийн эцсийн байдлаарх авлагын задаргаа

	(Төгрөгөөр)
Гуравдагч талаас авах авлага	-
Холбоотой талаас авах авлага	-
Найдваргүй авлагын нөөц	-
<b>Дансны авлага, цэвэр</b>	-
	-
Холбоотой талаас авах бусад авлага	-
Бусад татварын авлага	-
Гуравдагч талаас авах бусад авлага	-
Найдваргүй бусад авлагын нөөц	-
<b>Бусад авлага, цэвэр</b>	-
	-

### Дансны болон бусад өглөгийн задаргаа

12 дугаар сарын 31-ний өдрөөрх дансны болон бусад өглөгийн дансны үлдэгдэл дараах байдалтай байна:

Хүснэгт 10. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн 2020 оны жилийн эцсийн байдлаарх өглөгийн задаргаа

	(Төгрөгөөр)
<b>Дансны өглөг</b>	
Батбаяр энд партнэрс ХХК-д төлөх Хуулийн үйлчилгээний хөлс	22,000,000.00
Аудитын үйлчилгээний хөлс	900,000.00
Юу Эс Эф ХХК гэрээт ажлын өглөг	775,000.00
Андеррайтерийн үйлчилгээний хөлс	6,357,388.20
<b>Нийт дүн</b>	<b>30,032,388.20</b>
<b>Цалингийн өглөг</b>	<b>21,959,750.00</b>
<b>ХАОАТ болон НДШ-ын өр</b>	<b>6,413,241.81</b>
<b>Бусад богино хугацаат өр төлбөр</b>	
Богино хугацаат өр төлбөр	50,677,000.00
Толгой компани Субашид тек ХХК зээл	97,750,000.00
<b>Нийт дүн</b>	<b>148,427,000.00</b>

Дансны өглөг - 30,1 сая төгрөг

Компанид Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэх замаар өөрчлөн байгуулах болон нэмж энгийн хувьцаа олон нийтэд гаргахад зориулж Хуулийн дүгнэлт гаргуулсан бөгөөд нэмж энгийн хувьцаа гаргах хугацаа нь болоогүй учир гэрээний хугацаа дуусаагүй болно. Урьдчилсан байдлаар 2022 оны эхний улиралд гэрээний хугацаа дуусна.

Пи Кэй Эф Монголиа Аудит ХХК-иар хийлгэсэн аудитын үйлчилгээний хөлсний дутуу болно.

Юу Эс Эф ХХК-иар нягтлан бодох бүртгэлийг хөтлүүлсэний үйлчилгээний хөлс болно.

Компанид Эрдэнэс сольюшинс ХХК-ийг нэгтгэхдээ андеррайтерын үйлчилгээг Эс Жи Капитал ҮЦК-д төлөх үйлчилгээний хөлсний өрийн үлдэгдэл болно.

Богино хугацаат өр төлбөр - 148,2 сая төгрөг


Нэр бүхий 5 иргэнээс 30,6 сая төгрөгийг зээлсэнээс 2021 оны 01-р сард 23 сая төгрөгийг төлж барагдуулсан болно.

Толгой компани Субашид тек ХХК-иас 97,7 сая төгрөгийг 2022 оны 12-р сарын 31-ний өдрийг хүртэл хүүгүй зээлсэн бөгөөд цаашид сунгах боломжтой болно.

**7. Компанийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь хуулийн этгээд бол нэр, оршин байгаа хаяг, үйл ажиллагааны үндсэн чиглэл, компанийн нэгдэлд хамаардаг бол нэгдлийн гишүүн компанийн талаарх мэдээлэл, хяналтын багц, ҮЦЗТХ-ийн 4.1.30-д заасны дагуу тодорхойлсон холбогдох этгээдүүдийнх нь тухай мэдээлэл**

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан хувьцааны тоо 1 бүр нь 10 төгрөгийн нэрлэсэн үнэтэй 157,874,570 ширхэг бөгөөд 2021 оны 03 дугаар сарын 31-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын бүртгэх өдрийн байдлаар нийт 191 хувьцаа эзэмшигчтэй байна.

“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан энгийн хувьцааны 5-аас дээш хувийг эзэмшигч хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл болон нэгдмэл сонирхолтой этгээдүүдийн мэдээлэл:



“Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хувьцаа эзэмшигч Т. Дөлгөөн нь “Субашид тек” ХХК-ийн хувьцаа эзэмшигч Т. Золбоогийн төрсөн дүү бөгөөд эдгээр нь нэгдмэл сонирхолтой этгээдүүд юм.

“Субашид тек” ХХК-ийн 25%-ийг эзэмшигч, компанийн гаргасан энгийн хувьцааны 5.95%-ийг эзэмшигч Г. Дулмаа нь Компанийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Б.Батхүү нь төрсөн хүү бөгөөд компанийн 0.9 хувийг эзэмшигч, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн Ц. Хишигжаргал нь түүний хүргэн байна.

Компанийн энгийн хувьцааны 5 хувиас дээш хувьцаа эзэмшигч эдгээр 5 иргэн нь компанийн нийт энгийн хувьцааны 88.8%-ийг эзэмшдэг болно.

Хүснэгт 11. “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нийт гаргасан хувьцааг эзэмшигч Субашид тек ХХК

№	Нэр	Регистр	Хаяг	Хувьцааны тоо, хувь ЭЗЭМШИЛ
1	“Субашид тек” ХХК	6295541	Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 7/2, Денвер оффис, 4-р давхар	65.00%

#### “Субашид тек” ХХК-ийн товч танилцуулга

“Субашид тек” ХХК нь програм хангамжийн, компьютерийн тоног төхөөрөмжийн худалдаа чиглэлээр 2018 оны 04-р сарын 06-ны өдөр үүсгэн байгуулагдсан. Одоогоор зөвхөн хөрөнгө оруулалтын буюу “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн хувьцаа эзэмшин ажиллаж байна. компанийн энгийн хувьцааны 25%-ийг иргэн М.Бат-Эрдэнэ, Ц. Хүдэрмөнх, Т.Золбоо, Г.Дулмаа нар эзэмшдэг байна.

### **8. Компанийн сүүлийн 3 жилийн хугацаанд бусадтай байгуулсан гэрээ хэлцэл, их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй гэрээ хэлцлийн талаар**

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн сүүлийн 3 жил дотор буюу 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгосон өдрийн хооронд бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд КТХ-ийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

#### (i) Их хэмжээний хэлцэл

КТХ-ийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалт, 87.1.2 дахь заалт зэрэгт тус тус зааснаар “хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/ болон компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн

хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт”-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор хуульчилсан.

“Эрдэнэ сольюшинс” ХК-ийн сүүлийн 3 жил дотор буюу 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгосон өдрийн хооронд бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл 1 (нэг) гэрээ, хэлцэл гаргаж өгсөн. Тус гэрээ байгуулагдах өдрийн өмнөх тайлант хугацаа буюу 2016 оны хоёрдугаар улирлын санхүүгийн байдлын тайлангаас балансын нийт активын дүнг тооцож үзвэл 45,300 (дөчин таван мянга гурван зуун) төгрөг байна. Иймд тус гэрээ, хэлцлийн үнийн дүн нь балансын нийт активын 25 хувиас дээш хэмжээний үнийн дүнтэй гэрээ, хэлцэл биш байх тул их хэмжээний хэлцэл байгуулагдаагүй байна гэж үзлээ. Тус гэрээний талаарх мэдээллийг энэхүү Хуулийн дүгнэлтийн “сонирхлын зөрчилтэй хэлцэл” хэсгээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

**Нэгтгэн дүгнэж үзвэл “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн шилжүүлж өгсөн баримт материалаас үзвэл тус Компани нь сүүлийн 3 жилийн дотор их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.**

(ii) Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Хуулийн фирм нь “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн сүүлийн 3 жил дотор буюу 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгосон өдрийн хооронд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлүүдийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд КТХ-ийн дагуу хийгдсэн эсэхийг судалж үзлээ.

“Эрдэнэ сольюшинс” ХК нь сүүлийн 3 жил дотор буюу 2016 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөс 2019 оны 12 дугаар сарын 15-ны өдрөөр тасалбар болгосон өдрийн хооронд 1 (нэг) гэрээ, хэлцэл байгуулсан мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн болно. “Эрдэнэ сольюшинс” ХК болон “Эс Жи Капитал ҮЦК” ХХК-ийн хооронд “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ” (“Гэрээ”)-г 2015 оны 8 дугаар сарын 19-ны өдөр байгуулсан байна. Тус гэрээний талууд Гэрээний үндсэн дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан үнэт цаасыг хуульд заасны дагуу гаргахад андеррайтерийн үйлчилгээ үзүүлэхээр 4 (дөрвөн) жилийн хугацаатайгаар байгуулсан байх бөгөөд гэрээний утга, агуулга, талуудын тохиролцоог хууль тогтоомжид харшилсан нөхцөл, журам байхгүй байна гэж үзлээ.

Хуулийн фирмийн зүгээс тус Гэрээг сонирхлын зөрчилтэй хэлцэл гэж үзсэн бөгөөд КТХ-д заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлах журмын дагуу батална гэж үзсэн болно.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд КТХ-ийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт “сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхын саналаар гаргана” гэж заасан байна. “Эрдэнэ сольюшинс” ХК болон “Эс Жи Капитал ҮЦК” ХХК нарын хооронд “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх №01/2015 тоот гэрээ”-г байгуулах асуудлын хувьд ТУЗ-ийн 2015 оны 8 дугаар сарын 13-ны өдрийн №ТУЗТ03/2015 тоот “Сонирхлын зөрчилтэй “Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх” болон гэрээний хугацааг баталж, гэрээ байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгох тухай” тогтоол болон ТУЗ-ийн тэмдэглэлээс харвал энэхүү асуудлыг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн 100 хувийн саналаар шийдвэрлэсэн байна.

Иймд Хуулийн фирм нь тус Гэрээг хуульд заасан журмын дагуу байгуулсан гэрээ гэж дүгнэх үндэслэлтэй гэж үзлээ. Гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар Гэрээний хугацаа дуусгавар болсон байх бөгөөд МХБ-ийн 2020 оны 01 дүгээр сарын 14-ний өдрийн №01/26 тоот лавлагаанаас үзвэл “Эрдэнэ сольюшинс” ХК нь хувьцаанаас бусад үнэт цаас гаргаагүй болохыг тодорхойлсон байх тул тус Гэрээг хэрэгжээгүй гэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

“Эрдэнэ сольюшинс” ХК-аас гаргаж өгсөн нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлээс харвал тус Гэрээний гэрээлэгч тал нь Компанийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтад ороогүй

байгааг дурдаж байна. “Эрдэнэ сольюшинс” ХК-аас гаргаж өгсөн нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг Хавсралт №:01 “”Эрдэнэ сольюшинс” ХК-ийн нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалт”-аас танилцана уу. Тус мэдээлэл нь “Эрдэнэ сольюшинс” ХК-ийн хувьцаа эзэмшигч, эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн гэр бүлийн гишүүдийн хувийн мэдээллийг агуулсан хуулиар хамгаалагдсан хувь хүний нууцад хамаарах баримт тул төрийн эрх бүхий байгууллага болон одоогийн хувьцаа эзэмшигчид, ирээдүйн хөрөнгө оруулагчдаас бусад этгээдэд хаалттай, нууц мэдээлэлд тооцогдох болохыг анхаарч ажиллахыг Хуулийн фирмээс санал болгож байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс Компани өөрийн болон эрх бүхий албан тушаалтан, тэдгээртэй нэгдмэл сонирхолтой этгээдийн жагсаалтыг хөтөлж байх, уг жагсаалтад өөрчлөлт орсон тухай бүрд нь өөрчлөлтийг бүртгэх тухай хуулийн зүйл заалтыг анхаарч, судлах, нэгдмэл сонирхолтой этгээдийн бүртгэлийг нэг мөр болгож ажиллахыг зөвлөж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл “Эрдэнэ сольюшинс” ХК нь сүүлийн 3 жил дотор 1 (нэг) сонирхлын зөрчилтэй хэлцлийг ТУЗ-аас зөвшөөрөл олгосны үндсэн дээр байгуулсан байна гэж дүгнэх үндэслэлтэй байна.

---

## **9. Компанийн ноогдол ашгийн талаар**

---

### **Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэр:**

Компанийн санхүүгийн тайлан өнгөрсөн жил компани нэгтгэхтэй холбоотойгоор болон шинэ бүтээгдэхүүн хөгжүүлж байгаатай холбоотойгоор орлогын тайлан 161,8 сая төгрөгийн алдагдалтай гарсан. Компанийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.1, Компанийн ТУЗ-ын 2016 оны 05-р сарын 12-ны өдрийн хурлын ТУЗТ 03/2016 тоот тогтоолын 7-р хавсралтаар батлагдсан “Ноогдол ашгийн бодлого, шийдвэр гаргах, мэдээлэл тарааж олгох журам”-ын 1-р зүйлийн 1.1.2.Компанийн ногдол ашгийн ойрын ба хэтийн бодлого, хуваарилалт нь ирээдүйд компанид хөрөнгө оруулалт татахуйц байх, 1.1.3.Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээ нь компанийн тухайн жилийн бодит боломжоос хэтэрхий дээгүүр, эсхүл хэтэрхий доогуур биш байх, 1.1.4.Компанийн жилийн санхүүгийн тайланд тусгагдсан цэвэр ашгаас бизнес төлөвлөгөөнд тусгагдсан хөрөнгө оруулалт, нийгмийн арга хэмжээний хуваарилалтыг хасаад үлдэх хэсгийг ногдол ашигт хуваарилах зарчим баримтлах, 1.1.5.Хуваарилж буй ногдол ашгийн хэмжээг (тухайн санхүүгийн жилд олсон цэвэр ашиг нь өмнөх жилийнхээс буураагүй тохиолдолд) бууруулахгүй байх бодлого баримтлах нөхцөлүүдийг хангасан нөхцөл байхгүй ТУЗ-ын 2021 оны 02 дугаар сарын 23-ний өдрийн хурлын №ТУЗТ 01/2021 тоот тогтоолоор

“1.Компани 2020 оны ноогдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсүгэй.” Гэсэн шийдвэрийг гаргасан байна.

---

## **10. Охин компаниудын тухай**

---

### **Эрдэнэ капитал маркетс ХХК**

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2019.12.09
Регистерийн дугаар:	6504795
Хувь эзэмшил:	100%

### **Үйл ажиллагааны чиглэл**

Монгол Улсын Их Хуралд “Валютын зохицуулалтын тухай хууль” өргөн баригдаж энэ 2021 оны хаврын чуулганаар хэлэлцэгдэхээр төлөвлөгдөж байгаа бөгөөд өргөн баригдсан хуульд аж ахуйн нэгжүүд валютын бирж байгуулах тухай заалт орсон.

Валютын арилжааны програм хангамж, платформыг хөгжүүлж байгаа бөгөөд 2021 оны 4-р ажилуулахаар төлөвлөж байна.

### Санхүүгийн тайлан

Эрдэнэс капитал маркетс ХХК  
Санхүүгийн тайлан тэнцэл

ҮЗҮҮЛЭЛТ	2020	/төг/
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Бэлэн мөнгө		19,000.00
Авлага		-
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>19,000.00</b>
Үндсэн хөрөнгө		-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн		-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>		<b>19,000.00</b>
Өр төлбөр ба эзэмшигчдийн хөрөнгө		
Өр төлбөр		-
Богино хугацаат өр төлбөр		
Татвар, НДШ-ийн өр		-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>
Урт хугацаат өр төлбөр		
Банк санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл		-
Урт хугацаат өр төлбөрийн дүн		-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>		<b>-</b>
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал		
Энгийн хувьцаа		20,000.00
Давуу эрхтэй хувьцаа		-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/		(1,000.00)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>19,000.00</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>		<b>19,000.00</b>

### Эрдэнэс агро энд ресортс ХХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2020.03.16
Регистерийн дугаар:	6544991
Хувь эзэмшил:	100%

### Үйл ажиллагааны чиглэл

Сүүлийн үед хаа-г технологижуулах үйл явц олон улсад идэвхжиж байгаа бөгөөд үхрийн махны чиглэлийн аж ахуй байгуулж түүнийг технологижуулах ялангуяа үхрийн хээлтүүлэг, хариулга, тэжээлд чип, дрон, тусгай програм хангамжийг ашиглах болсон. Ялангуяа Израйл, Франц улсын технологийг нутагшуулах экспортод мах гаргах, хаа-г дагасан аялал жуулчлалыг хөгжүүлэх зорилгоор байгуулсан. Төв болон Сэлэнгэ аймагт газрын судалгаа хийж байгаа 2022 оноос үйл ажиллагааг идэвхжүүлэхээр төлөвлөж байна.

### Санхүүгийн тайлан

Эрдэнэс агро энд ресорте ХХК  
 Санхүүгийн тайлан тэнцэл

	/төг/
ҮЗҮҮЛЭЛТ	2020
Хөрөнгө	
Эргэлтийн хөрөнгө	
Бэлэн мөнгө	14,000.00
Авлага	-
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>14,000.00</b>
Үндсэн хөрөнгө	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>14,000.00</b>
Өр төлбөр ба эзэмшигчдийн хөрөнгө	
Өр төлбөр	-
Богино хугацаат өр төлбөр	
Татвар, НДШ-ийн өр	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>
Урт хугацаат өр төлбөр	-
Банк санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>
Эзэмшигчдийн өмч	
Хувьцаат капитал	
Энгийн хувьцаа	20,000.00
Давуу эрхтэй хувьцаа	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(6,000.00)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>14,000.00</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>14,000.00</b>

**Эрдэнэс рийл эстэйт ХХК**

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2020.03.26
Регистерийн дугаар:	6548989
Хувь эзэмшил:	100%
Тусгай зөвшөөрөл:	Үл хөдлөх хөрөнгө зуучлал

**Үйл ажиллагааны чиглэл**

“Хар хорум пропертийс” ХК нь үл хөдлөх хөрөнгө зуучлалын чиглэлээр үйл ажиллагаа эрхэлж байсан бөгөөд ТУЗ-ын 2020 оны 03 дугаар сарын 19-ний өдрийн ТУЗТ 06/2020 тоот тогтоолоор “Эрдэнэс рийс эстэйт” ХХК-ийг үүсгэн байгуулж үйл ажиллагааг тусгаарласан. СЗХ-ны 2020 оны тоот ТЗ 601/54 тогтоолоор үл хөдлөх хөрөнгийн зуучлалын тусгай зөвшөөрөл авсан.

Үл хөдлөх хөрөнгө бүртгэлийн програм хангамж, платформыг хөгжүүлж байгаа бөгөөд 2022 оны 1-р улиралд ажилуулахаар төлөвлөж байна.

**Санхүүгийн тайлан**

 Эрдэнэс рийл эстэйт ХХК  
 Санхүүгийн тайлан тэнцэл

	/төг/
ҮЗҮҮЛЭЛТ	2020
Хөрөнгө	
Эргэлтийн хөрөнгө	
Бэлэн мөнгө	13,000.00
Авлага	20,000,000.00
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>20,013,000.00</b>

Үндсэн хөрөнгө	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>20,013,000.00</b>
Өр төлбөр ба эзэмшигчдийн хөрөнгө	
Өр төлбөр	-
Богино хугацаат өр төлбөр	
Татвар, НДШ-ийн өр	-
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>
Урт хугацаат өр төлбөр	-
Банк санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>
Эзэмшигчдийн өмч	
Хувьцаат капитал	
Энгийн хувьцаа	20,020,000.00
Давуу эрхтэй хувьцаа	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(7,000.00)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>20,013,000.00</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>20,013,000.00</b>

### 11. Худалдан авч буй охин компанийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан

#### Мөнгөн морь констракшн ХХК

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2014.02.14
Регистрийн дугаар:	5799961
Хувь эзэмшил:	85%
Тусгай зөвшөөрөл:	Барилга угсралт

#### Үйл ажиллагааны чиглэл

Барилга угсралтын тусгай зөвшөөрөл бүхий компани бөгөөд олон улсад барилга угсралтад 3D, роботыг өргөн ашиглаж барилгыг хурдан хугацаанд, чанартайгаар барих болсон.

#### Санхүүгийн тайлан

Мөнгөн морь констракшн ХХК Санхүүгийн тайлан тэнцэл		/төг/
ҮЗҮҮЛЭЛТ	2020	
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Бэлэн мөнгө	399,582,260.00	
Авлага	-	
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>399,582,260.00</b>	
Үндсэн хөрөнгө	2,695,000.00	
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,695,000.00	
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>402,277,260.00</b>	
Өр төлбөр ба эзэмшигчдийн хөрөнгө		
Өр төлбөр	-	
Богино хугацаат өр төлбөр		
Татвар, НДШ-ийн өр	-	
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>	
Урт хугацаат өр төлбөр	-	
Банк санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	-	



Урт хугацаат өр төлбөрийн дүн	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>-</b>
Эзэмшигчдийн өмч	
Хувьцаат капитал	
Энгийн хувьцаа	402,560,000.00
Давуу эрхтэй хувьцаа	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	(282,740.00)
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>402,277,260.00</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>402,277,260.00</b>

### Эйс ассошиэйтс ББСБ

Улсын бүртгэлд бүртгэсэн огноо:	2012.11.19
Регистерийн дугаар:	5651077
Хувь эзэмшил:	85%
Тусгай зөвшөөрөл:	Гадаад валютын арилжааны үйл ажиллагаа

### Үйл ажиллагааны чиглэл

Компани банк бус санхүүгийн байгууллагын үндсэн модул, зээлийн үйл ажиллагааны зээлжих зэрэглэлийн системийг хөгжүүлж байгаа бөгөөд зээлийн үйл ажиллагааг онлайн байдлаар бичил зээл олгоно. ББСБ дах хувь эзэмшлээ 2021 оны 3-р улирал гэхэд 95%-д хүргэхээр төлөвлөж байна.

Програм хангамжыг 2021 оны 3-р улиралд ажилуулахаар төлөвлөж байна.

### Санхүүгийн тайлан

Тус компанийн аудитлагдсан тайланг сүүлийн 2 жилээр зэрэгцүүлэн харуулбал дараах байдалтай байна.

Эйс ассошиэйтс ББСБ  
Аудитлагдсан санхүүгийн тайлан тэнцэл

ҮЗҮҮЛЭЛТ	2019	2020
/төг/		
Хөрөнгө		
Эргэлтийн хөрөнгө		
Бэлэн мөнгө	860,033,468.31	4,978,919.80
Авлага	-	855,000,000.00
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>	<b>860,033,468.31</b>	<b>859,978,919.80</b>
Үндсэн хөрөнгө	-	-
Эргэлтийн бус хөрөнгийн дүн	-	-
<b>Нийт хөрөнгийн дүн</b>	<b>860,033,468.31</b>	<b>859,978,919.80</b>
Өр төлбөр ба эзэмшигчдийн хөрөнгө		
Өр төлбөр	-	-
Богино хугацаат өр төлбөр		
Татвар, НДШ-ийн өр	245,096.65	245,096.65
<b>Богино хугацаат өр төлбөрийн дүн</b>	<b>245,096.65</b>	<b>245,096.65</b>
Урт хугацаат өр төлбөр	-	-
Банк санхүүгийн байгууллагаас авсан урт хугацаат зээл	-	-
Урт хугацаат өр төлбөрийн дүн	-	-
<b>Нийт өр төлбөрийн дүн</b>	<b>245,096.65</b>	<b>245,096.65</b>
Эзэмшигчдийн өмч		
Хувьцаат капитал		
Энгийн хувьцаа	851,000,000.00	851,000,000.00

Давуу эрхтэй хувьцаа	-	-
Хуримтлагдсан ашиг /алдагдал/	8,788,371.66	8,733,823.15
<b>Эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>859,788,371.66</b>	<b>859,733,823.15</b>
<b>Өр төлбөр ба эзэмшигчдийн өмчийн дүн</b>	<b>860,033,468.31</b>	<b>859,978,919.80</b>

Компанийн хаяг Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 7/2, Денвер оффис, 4-р давхар

Холбоо барих утас (976)-11-99037119  
Вэб сайт [www.erdenes.solutions](http://www.erdenes.solutions)  
И-мэйл Info@erdenes.solutions